

**МУИС-ийн ХШУИС-ийн захиралд нэр дэвшигч доктор Н.Оюун-Эрдэний багш нарт хандсан  
захидал, мөрийн хөтөлбөр, товч намтар**

ХШУИС-ийн нийт багш, судлаач нарт

Миний бие Н.Оюун-Эрдэнэ нь МУИС МКС-д Програм хангамжийн инженер, 2000-2002 онд МУИС МКС-д математикийн ухааны магистрант, 2004-2008 онд Солонгосын Чунгбук үндэсний их сургуульд докторантаар суралцан төгсөж, нийтдээ эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг 21 жил тасралтгүй хийж ирлээ.

Докторын зэрэг хамгаалах, зочин профессороор ажиллах, олон улсын төсөлд ажиллах, олон улсын цуврал хурал 13 жил удирдан зохион байгуулах хугацаандаа Солонгос, Хятад, Вьетнам, Сингапур, Тайланд, Япон, Латви, Орос, Грек, Герман, Америк, Европын холбоо зэрэг газрын улсын болон хувийн их дээд сургуультай хамтран ажиллаж дээд боловсролын дэлхийн практик туршлагыг тодорхой хэмжээгээр судлан, удирдаж буй тэнхимийнхээ хөтөлбөрүүдийг олон улсын жишигт хүргэх, сургалт, судалгааны ажлыг дэлхийн жишигт хүргэн ажиллах зорилго тавин ажилласаар ирлээ.

Манай тэнхимийн хамт олон сургалт, судалгааны ажлыг жилээс жилд сайжруулан, олон улсын хамтарсан сургалт зохион байгуулах, хөтөлбөрүүдээ дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлэх ажлуудыг амжилттай гүйцэтгэж МУИС-ийн нийт тэнхим, нэгжүүдтэй хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн сайн туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж байна. Мөн түүнчлэн дотоодын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрүүдээс тэнхим, сургуульдаа хөрөнгө оруулалт хийлгэх замаар сургалт, судалгааны орчингоо сайжруулах, сургалт, судалгааны шинэ лабораториуд нээх талаар бодит ажлуудыг хийн багш, оюутны ажиллаж, суралцах орчинг тасралтгүй сайжруулан ажиллаж байна. Бид МУИС-ийн эрхэм зорилго, зорилтод нийцүүлэн ХШУИС-ийн стратеги төлөвлөгөөний биелэлтийг түлхүүр үзүүлэлт нэг бүрээр гүйцэтгэл өндөртэй ажиллах зорилго тавин, хичээлийн жилээр төлөвлөн ажиллаж ирлээ.

Эдийн засаг, улс төр, нийгэмд өөрчлөлт авч ирэх “Аж үйлдвэрийн 4-р хувьсгал” дэлхий нийтээр явагдаж байгаа өнөө үед технологийн дэвшлийг инженерийн салбарт нэвтрүүлэн, дэлхийд хийгдэж байгаа судалгааны ажлыг хийх, ингэхдээ улс орныхоо хөгжилд үсрэнгүй хувьсал авч ирэх боловсон хүчнийг бэлтгэн гаргах нь та бидний эрхэм зорилго болоод байгаа билээ.

Бид “сайн оюутан, сайн багш, сайхан орчин”-тай байх өөрөөр хэлбэл шилдэг сурагчийг элсүүлэн, эх орондоо болон олон улсад эрэлттэй шилдэг мэргэжилтэн болгон бэлтгэж; шилдэг багшийг шалгаруулан авч, түүний нийгмийн болон эрдэм, судлалын ажил, сурган заах арга зүйн хөгжилд нь тасралтгүй дэмжлэг үзүүлэн, эрүүл саруул, сэтгэл хангалуун ажиллах орчинг бүрдүүлэхэд санхүүгийн болон мэргэжилтний тусламж, дэмжлэгийг үзүүлэх, багшийн цалинг дэлхийн жишигт дөхүүлэн нэмэгдүүлэх; сургалт, судалгааны орчинг сайжруулах, шинэчлэх ажлыг хийх шаардлагатай байна.

Салбар сургууль, хөтөлбөр нэгжүүдийн хөгжлийн хамгийн оновчтой зам, стратегийг сонгох, сургуулиа хөгжүүлэн дэлхийн жишигт хүргэхэд та бүгдийн итгэлийг хүлээн ажиллаж чадна гэдэгтэй итгэлтэй байна.

Иймд та бүхэн сонгуульд идэвхитэй оролцож, өөрийн санал бодлоо хэлж, сургуулийн ирээдүйг тодорхойлох үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно гэж найдаж байна.

**МУИС, ХШУИС Н.Оюун-Эрдэнэ.**